



I–III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13



## Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 138.4 (24.4%) тэрбум төгрөгөөр өслөө


Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний улиралд 785.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.7 (2.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс өсөхөд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 31.1 (39.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөгөөр, сараар



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500000 (таван зуун мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны эхний улирлын байдлаар 466.8 мянган хүнд 706.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 13.0 (2.9%) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэврийн хэмжээ 138.4 (24.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 2022 оны эхний улиралд 52.6 мянган хүнд 7.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 33.8 (2.8 дахин) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 2.5 (48.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд Коронавирусийн халдварын улмаас өвчилсөн даатгуулагчийн тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Нийгмийн халамжийн сангаас 2022 оны эхний улиралд давхардсан тоогоор 972.1 мянган хүнд 151.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 1.2 (56.1%) саяар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 360.9 (70.4%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо болон нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулиас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хассантай холбоотойгоор буурлаа.

Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 4 дүгээр сараас 2023 оны 1 дүгээр сарыг хүртэл 288.0 мянган төгрөгөөр олгож байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2022 оны эхний улиралд 55.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.7 (3.2%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 45.9 тэрбум төгрөг болж 25.4 (0.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 65.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 26.4 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 8.2 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2022 оны эхний улиралд 103.4 мянган хүн хамрагдсаны 52.8 хувь нь асаргааны тэтгэмжид, 47.2 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2022 оны эхний улиралд 25.5 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1.1 (4.4%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022 I-III	2022 I-III 2021 I-III
	хүн				хувь
<b>Бүгд</b>	<b>1 867 956</b>	<b>2 079 355</b>	<b>2 213 789</b>	<b>972 087</b>	<b>43.9</b>
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	376 827	373 976	370 281	309 247	83.5
Тэтгэвэр	52 812	53 606	53 970	55 690	103.2
Тэтгэмж	72 152	80 152	82 469	103 374	125.3
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	251 863	240 218	233 842	150 210	64.2
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	205 923	211 469	228 216	234 701	102.8
Хүүхдийн мөнгөн тэтгэмж <sup>1*</sup>	911 035	1 113 047	1 195 816	-	-
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	39 138	37 382	64 161	72 806	113.5
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2 294	2 388	60	196	3.3 <sup>1</sup>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	7 111	8 063	6 209	5 903	95.1
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	198 053	197 719	205 540	196 554	95.6
Насны хишиг	127 227	134 945	143 113	152 274	106.4
Цаатан иргэний тэтгэмж	348	366	393	379	96.4

\*Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн халамжийн сангаас хүүхдийн мөнгөн тэтгэмж олголтыг зогсоосон.

<sup>1</sup>Тухайн сараар

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2022 оны эхний улиралд 150.2 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 83.5 (35.7%) мянган хүнээр буурсан нь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

### Ойлголт, тодорхойлолт

**Нийгмийн даатгал:** Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан:** Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч:** Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр:** Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж:** Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.



**Эх үүсвэр:**

Нийгмийн даатгалын ерөнхий газар,  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 7 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн  
газрын дарга А.Амарбал  
Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын Нийгмийн  
статистикийн хэлтсийн статистикч  
Э.Ариунчимэг  
Утас : (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212